

# **“БҮХНИЙГ ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ” ТББ-ЫН ДҮРЭМ**

## **1. НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

Энэхүү дүрэм нь Монгол Улсын Үндсэн хууль, ТББ-ын тухай хууль болон бусад холбогдох хууль эрх зүйн баримт бичиг, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ хэлцлийн утга агуулгад нийцсэн бөгөөд тус байгууллагын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн баримт бичиг байна.

1.1 Байгууллагын нэр: “Бүхнийг Хүүхдийн Төлөө” ТББ гэсэн нэртэй байна.

Байгууллагын хаяг: Монгол улс, Дорнод аймаг, Хэрлэн сумын 10-р баг 3-р байрны 2-р орцны 12 тоот

Харилцах утас: 99583663, 88587553

1.2 Байгууллагыг үүсгэн байгуулсан он, сар, өдөр:

2007 оны 8-р сарын 10-ны өдөр

1.3 “Бүхнийг Хүүхдийн Төлөө” ТББ нь хүүхдийн төлөө ажиллах хүсэл зорилгынхоо дагуу сайн дураараа эвлэлдэн нэгдэж үүсгэн байгуулсан ашиг үл горилох нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллага байна.

1.4 Тус ТББ-ын үйл ажиллагааны үндсэн төв нь Дорнод аймаг байна.

1.5 Үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүд болон өөрийн дүрмийг мөрдлөг болгоно.

1.6 Байгууллага нь албан бичгийн нүүр, тамга тэмдэгтэй байна.

## **2. ХОЁР. ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА**

2.1 Монголын ирээдүй болсон хүүхэд залуучуудыг бие бялдар, ёс суртхуун, сэтгэл зүйг нь төлөвшүүлэх, сурч боловсрох ач холбогдлыг ойлгуулан мөн хүүхэд залуучуудыг өөрийгөө хөгжүүлэх зэргээр нийгэмд өөрийгөө зохистойгоор авч явах чадвартай бие хүнийг төлөвшүүлэхэд туслах гэсэн ерөнхий зорилгын хүрээнд дараахь чиглэлийн үйл ажиллагааг эрхлэн явуулна. Үүнд:

2.1.1 Хүүхдүүдэд зориулсан тэдний эрх ашгийг хангах, боловсрол, мэдлэг мэргэжлийн ач холбогдлын талаарх материалыг боловсруулан гаргах, түгээх, энэ талаар хүүхдүүдэд сургалт зохион байгуулах;

2.1.2 Нийгмийн эмзэг бүлгийн хүүхдүүдын ахуй амьдралд тус дэм болох зорилгоор хүмүүнлэг энэрэнгүйн ажлыг хийх;

2.1.3 Нийгэмд биеэ даан авч явахад туслах зорилгоор албан бус сургалтуудад хамруулан тодорхой мэргэшил, дадлагатай болгох

2.1.4 Өөрсдийн зорилгын хүрээнд, нийгэмд буй төрийн болон төрийн бус байгууллага, хамт олон, гадаад дотоодын хүүхдийн төлөө үйл ажиллагаа эрхлэгч байгууллага, хувь хүмүүстэй харилцаа

- холбоо тогтоон, хамтран ажиллаж, аль болох олон хүүхдэд үр дүнтэй туслалцаа үзүүлэхийг эрмэлзэх;
- 2.1.5 Хүүхдийн хүмүүжил, ёс зүй, сэтгэл санааны зөв төлөвшилд нөлөөлөхүйц төрөл бүрийн сонирхолтой сургалтуудыг зохион байгуулах, хөгжингүй улс орнуудын дэвшилтэт арга хэлбэрийг авч хэрэглэх;
- 2.1.6 Хүүхдийн эрх чөлөөг хангах, хамгаалах талаар хүүхдүүдэд зориулсан хөтөлбөр боловсруулах, хамтран ажиллах;
- 2.1.7 Өөрсдийн зүгээс хүмүүнлэгийн салбарт хийж байгаа идэвхитэй үйл ажиллагаануудын талаар үнэн зөв мэдээллийг төвлөрүүлж олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулах буюу бие даан нийтэд мэдээлэх ажлыг эрхлэн явуулах;

### **3 ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ**

- 3.1 Байгууллага нь үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн ба төрийн бус байгууллагуудтай эрх тэгш харилцах эрхтэй.
- 3.2 Дэмжигчдээс гарсан санал, гомдлыг хянан үзэж, шаардлагатай гэж үзвэл холбогдох байгууллагад албан ёсоор асуудал тавьж хариу авах эрхтэй.
- 3.3 Өөрийн салбар нэгжийг орон нутагт байгуулах, гадаадад төлөөлөгчийн газраа нээж ажиллуулах эрхтэй.
- 3.4 Зорилго нэгтэй дотоод гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах, эвлэлдэн нэгдэх, гишүүнээр элсэх эрхтэй.
- 3.5 Үйл ажиллагааны хүрээнд бүх төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглана.
- 3.6 Үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийг хүндэтгэн дагаж, ардчилсан зарчмаар нийгэмд нээлттэй байна.
- 3.7 Байгууллагаас хийгдэж буй ажил болон ирээдүйд хийгдэх ажлын талаархи мэдээг сар бүр холбогдох хүмүүст мэдээлэх бөгөөд тэдний хүсэлт, санаачлагыг өөрсдийн үйл ажиллагаандаа тусган ажиллана
- 3.8 Тус байгууллагын удирдах албан тушаалтан болон гишүүд, үйл ажиллагаанд оролцож буй хувь хүний хууль бус ажиллагааны улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан хохирол, түүнээс үүсэн гарах аливаа хариуцлагыг байгууллага хүлээхгүй.

### **4 ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ЗҮГЭЭС ЭРХЛЭН ЯВУУЛАХЫГ ХОРИГЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

- 4.1 Байгууллагын нэрээр аливаа улс төрийн үйл ажиллагаанд оролцож сонгуульд нэр дэвшүүлэх болон аль нэгэн намын талаар сурталчилгаа хийх нам, эвсэл, хэсэг бүлэг, хувь хүнийг дэмжин оролцох
- 4.2 Иргэд байгууллагад хөрөнгийн баталгаа гаргах, бусдын аж ахуйн үйл ажиллагаанаас учирсан хохирлыг нөхөн төлөхөд оролцох

### **5 ТАВ. УДИРДАХ ЗӨВЛӨЛ**

- 5.1 Удирдах зөвлөл нь эрх барих дээд байгууллага юм. Удирдах зөвлөлийн хурал, түүний эрх үүрэг
- 5.1.1 Зөвлөлийн хурал нь жилд 4 удаа, улиралд нэг удаа хуралдах бөгөөд шаардлагатай гэж үзвэл ээлжит бус хурлыг тус дүрэмд заасныг үндэслэн зарлан хуралдуулна.

- 5.1.2 Хурал нь оролцвол зохих гишүүдийн гуравны хоёр ба түүнээс дээш оролцоотой нөхцөлд хүчин төгөлдөр байна. Тухайн хурлаас дараагийн хурлыг товлох бөгөөд зарыг хуралд оролцоогүй гишүүнд бичгэн хэлбэрээр мэдэгдэнэ.
  - 5.1.3 Удирдах зөвлөл нь 5 гишүүнтэй байх бөгөөд 3 жилийн хугацаатай 2 удаа улиран сонгогдох боломжтой.
  - 5.1.4 Зөвлөлийн хурлыг тухай бүр нь зөвлөлийн тэргүүн зарлан хуралдуулах ба түүний эзгүйд гүйцэтгэх захирал зарлан хуралдуулна.
  - 5.1.5 Зөвлөлийн ээлжит бус хуралдааныг зөвлөлийн тэргүүн болон зөвлөлийн гишүүдийн 3/1-ээс доошгүй нь зарлан хуралдуулж болох бөгөөд энэ тохиолдолд зөвлөлийн тэргүүн хурлыг даргална.
  - 5.1.6 Зөвлөлийн хурлыг зөвлөлийн тэргүүн удирдан явуулах бөгөөд түүний эзгүй тохиолдолд сонгогдсон дэд тэргүүн удирдан явуулна.
  - 5.1.7 Зөвлөлийн гишүүн бүр саналын нэг эрхтэй байна.
  - 5.1.8 Зөвлөлийн гишүүд аливаа асуудлыг шийдвэрлэхэд тэгш эрхтэй байх бөгөөд шаардлагатай гэж үзсэн зарим нэг асуудлыг нууц санал хураах зарчмаар бусад асуудлыг ил санал хурааж, олонхийн санал авсан асуудлыг шийдвэрлэгдсэнд тооцно.
  - 5.1.9 Удирдах зөвлөлийн санал хураалтанд аль нэгэн гишүүнийг оролцуулах шаардлагагүй гэж зөвлөлөөс үзэх эсвэл гишүүн санал хураалтанд оролцох бололцоогүй байгаа бол энэ тухай албан ёсоор мэдэгдэнэ.
  - 5.1.10 Удирдах зөвлөлийн хурлаар хувь хүний эзгүйд түүнтэй холбоотой аливаа асуудлыг хэлэлцэх, шийдвэр гаргахыг хориглоно.
  - 5.1.11 Хурлаар хэлэлцсэн асуудал, шийдвэрийг протоколд тэмдэглэх ба уг протоколд санал хураалтад оролцсон зөвлөлийн тэргүүн бичиг хэрэг хөтлөгч нар гарын үсэг зурж баталгаажуулна. Тухайн протоколыг гишүүн бүрт тараан олгоно.
- 5.2 Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудал
    - 5.2.1 Байгууллагын удирдах зөвлөлийн тэргүүнийг сонгох
    - 5.2.2 Байгууллагын санхүүгийн болон ажлын тайланг хэлэлцэн батлах
    - 5.2.3 Байгууллагын ажлын албаны бүтэц, зохион байгуулалтыг батлах, үйл ажиллагааны талаар тайланг авч хэлэлцэх
    - 5.2.4 Байгууллагын гүйцэтгэх захирлыг томилж, чөлөөлөх, түүний эрх үүргийг тодорхойлох
  - 5.3 Удирдах зөвлөлийн тэргүүний эрх, үүрэг
    - 5.3.1 Удирдах зөвлөлийн тэргүүний бүрэн эрхийн хугацаа 2 жил байх бөгөөд улируулан сонгож болно.
    - 5.3.2 Өөрийн бүрэн эрхийн хугацаа дууссан нөхцөлд ба хүндэтгэх шалтгааны улмаас дараагийн шинээр сонгогдсон хүнд эрхээ шилжүүлэх хүртэл албан үүргээ биелүүлж байна.
    - 5.3.3 Удирдах зөвлөлийн тэргүүн нь зөвлөлөөс гаргасан шийдвэрийн дагуу Гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулна. Гүйцэтгэх захирлын цалин урамшууллын талаар өөрийн саналаа боловсруулан зөвлөлд оруулна.
    - 5.3.4 Зөвлөлийн хуралдааныг даргалах
    - 5.3.5 Зөвлөлийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах
    - 5.3.6 Удирдах зөвлөлийн тэргүүн ёс зүйн болон хууль эрхий зөрчил гаргах, жилээс дээш хугацаагаар албан үүргээ хэвийн гүйцэтгэх бололцоогүй болох нь түүнийг албан тушаалаас нь чөлөөлөх үндэслэл болно.
  - 5.4 Удирдах зөвлөлийн гишүүдийн эрх, үүрэг

- 5.4.1 Удирдах зөвлөлийн гишүүд нь ямар нэг цалинтай адилтгах урамшуулал авахгүй. Сайн дурын үндсэн дээр ажиллана.
- 5.4.2 Бүх шатны ажилд тэгш эрх, үүрэгтэйгээр оролцоно.
- 5.4.3 Байгууллагыг байгуулахад болон бусад ажил үйл ажиллагаанд хувиасаа гаргасан зардлаа нөхөн авах эрхтэй.
- 5.4.4 Удирдах зөвлөлийн гишүүн нь тус байгууллагын нэр хүнд, үйл ажиллагаанд хохирол учруулахаар ёс суртахууны болон бодит үйлдэл хийсэн тохиолдолд удирдах зөвлөлийн гишүүнээс шууд чөлөөлж, учирсан хохирол бусад асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлнэ
- 5.4.5 Удирдах зөвлөлийн гишүүд нь удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох эрхтэй.

## **6 ЗУРГАА. ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ЭРХ, ҮҮРЭГ**

- 6.1 Гүйцэтгэх захирлыг Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж сонгон томилоно.
- 6.2 Гүйцэтгэх захирал нь байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг ажлын албаны тусламжтайгаар явуулж, удирдлага зохион байгуулалтаар хангана.
- 6.3 Удирдах зөвлөлийг мэдээллээр хангах, улирал тутамд түүнд ажлаа тайлагнах, шийдвэрийн төсөл боловсруулах, санхүүгийн тайлан бичгээр гаргах үүрэгтэй.
- 6.4 Гүйцэтгэх захирал нь байгууллагын хүрээнд бусад ажил үүрэг хавсран гүйцэтгэж болохгүй.
- 6.5 Гүйцэтгэх захирал нь удирдах зөвлөлийн хурлаас олгосон эрх үүргийн хүрээнд байгууллагын өмч хөрөнгийг захиран зарцуулах эрхтэй.
- 6.6 Гүйцэтгэх захирал нь тодорхой олгогдсон эрх үүргийн хүрээнд байгууллагыг гадаад, дотоодод төлөөлөх эрхтэй.
- 6.7 Гүйцэтгэх захирал нь орон тооны ажилтан байна.
- 6.8 Гүйцэтгэх захирал нь санхүүгийн баримт бичигт 1-р гарын үсэг зурах эрхтэй бөгөөд түүний мэдэж зарцуулах жилийн төсвийг зөвлөлөөс тогтооно.
- 6.9 Гүйцэтгэх захирал нь хандивын болон төсөл хэрэгжүүлэхэд зориулагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах үүрэгтэй бөгөөд түүний зарцуулалтын тайланг хандивлагч байгууллага болон Зөвлөлд тухай бүр тайлагнаж байх үүрэгтэй.
- 6.10 Хэрэв Удирдах зөвлөлөөс өөр журам тогтоогоогүй бол ажлын албаны бусад ажилтныг томилох, чөлөөлөх үүргийг байгууллагын орон тооны хүрээнд бие даан шийдвэрлэнэ.
- 6.11 Гүйцэтгэх захирал нь ажлын албаны дотоод дүрмийг баталж мөрдүүлэх ба удирдлага зохион байгуулалтаар хангана.
- 6.12 Байгууллагын жилийн тайланг хуульд заасан хугацаанд эрх бүхий төрийн байгууллагад хүргүүлнэ.
- 6.13 Гүйцэтгэх захирал нь удирдах зөвлөлийн хуралд саналын эрхгүй оролцож болно.
- 6.14 Гүйцэтгэх захирлын ажил үүргийн хуваарь, хүлээх хариуцлага, хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл, цалин урамшуулал зэрэг асуудлыг түүнтэй байгуулах гэрээнд нарийвчлан тусгасан байна.

## **7 ДОЛОО. САНХҮҮЖИЛТ**

- 7.1 Байгууллага нь өөрийн үйл ажиллагааг хэвийн явуулах үүднээс санхүүгийн бүх төрлийн харилцаанд оролцоно.
- 7.2 Байгууллага нь дараах эх үүсвэрээр санхүүжнэ. Үүнд

- 7.2.1 Иргэд аж ахуйн нэгж, байгууллагын сайн санааны хандив.
  - 7.2.2 Гадаадын хүмүүнлэгийн болон тусламжын байгууллага, иргэдийн хандив, тусламж
  - 7.2.3 Зээлийн хөрөнгө
  - 7.2.4 Төслийн шугамаар санхүүжүүлэгдэж буй хөрөнгө
  - 7.2.5 Өвлүүлсэн хөрөнгө
  - 7.2.6 Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдон хэрэгжүүлэх төрөл бүрийн үйл ажиллагаанаас олох орлого
- 7.3 Байгууллагаас цалинжиж буй ажилтны эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийг хууль тогтоомжийн хүрээнд төлнө.
  - 7.4 Байгууллагын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн бүртгэл тооцоог ажлын алба хариуцна.
  - 7.5 Байгууллагын орлого, зарлага нь нийтэд нээлттэй байна.

## **8 НАЙМ. БАЙГУУЛЛАГЫГ ТАТАН БУУЛГАХ ТУХАЙ**

- 8.1 Байгууллагыг дараах үндэслэлээр татан буулгах саналыг удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж эцэслэн шийдвэрлэнэ.
  - 8.1.1 Дүрмийн зорилго, үйл ажиллагааныхаа чиглэлийг хэрэгжүүлж дууссан гэж үзвэл
  - 8.1.2 Байгууллага нь өөрийн үйл ажиллагаандаа Монгол улсын хууль эрх зүйн актыг зөрчсөн нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон
- 8.2 Татан буулгасан тухай шийдвэрээ эрх бүхий төрийн захиргааны байгууллагад албан ёсоор мэдэгдэнэ.
- 8.3 Байгууллагыг татан буулгасан тохиолдолд авсан зээл, төсөл хэрэгжүүлэхтэй холбогдуулан авсан хөрөнгө, байгууллагыг татан буулгасан тухай мэдээлэл хийхэд зарцуулсан зардал зэрэг бусад өр төлбөрийг барагдуулсаны дараа бусад бүх эд хөрөнгийг ижил төстэй зорилго бүхий байгууллагад шилжүүлэн үлдэнэ. Эд хөрөнгийг шилжүүлэн үлдээх асуудлыг байгууллагын бүх гишүүдийн хурал эцэслэн шийдвэрлэнэ.

## **9 ЕС. БАЙГУУЛЛАГЫН ДҮРЭМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ**

- 9.1 Байгууллагын дүрэмд нэмэлт өөрчлөлтийг удирдах зөвлөлийн хурлаар авч хэлэлцэнэ.
- 9.2 Дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлтийг бүх гишүүдийн хурлын 2/3-оос дээш хувийн саналаар шийдэж батална.
- 9.3 Байгууллага нь дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлтийнхөө талаар албан ёсоор эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

**10 “БҮХНИЙГ ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ” ТББ****УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН  
ТОВЧ АНКЕТ**

№	Овог нэр	Гүйцэтгэх үүрэг	Иргэний үнэмлэх \ регистерийн дугаар	Ажлын хаяг, албан тушаал	Гэрийн хаяг
1.	Пүрэвжил Мөнхөө	Гишүүн	ДО4261082 ЖЯ69020111	Дөрөөт төвийн захирал	Дорнод аймаг, Хэрлэн сум, 7-р баг Дөрөөт
2.	Цэрэнчимэд Ганбат	Гишүүн	ДО4240222 ЖЯ58052411	БОЭТ-ийн дарга	Дорнод аймаг, Хэрлэн сум, 6-р баг Өнөр 20-25 тоот
3.	Нямдорж Ганбаатар	Гишүүн	ДО4285552 ЖЮ56061813	АХАЯБХолбооны тэргүүн	Дорнод аймаг, Хэрлэн сум 9-р баг 3-54 тоот
4.	Дорж Энхтуяа	Гишүүн	ДО4282969 ЖЯ70040126	Багш	Дорнод аймаг, Хэрлэн сум, 9-р баг 5-40 тоот
5.	Рэнцэн Сүрлэгмаа	Гишүүн	ДО4261492 ЖЯ66031609	Гэр санаачлага төсөл, англи хэлний орчуулагч	Дорнод аймаг, Хэрлэн сум, 4-р баг, БК байр 7-8 тоот